



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/153

Мандалговь

“Одда тайж” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/121 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сум эрүүл мэндийн төвийн их засварын ажил” (Дундговь, Баянжаргалан сум)”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Одда тайж” ХХК-тай 195,145,055 (нэг зуун ерэн таван сая нэг зуун дөчин таван мянга тавин тав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Сум эрүүл мэндийн төвийн их засварын ажил” (Дундговь, Баянжаргалан сум)” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Одда тайж” ХХК-ийн захирал (Д.Ундармаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Баянжаргалан сумын Засаг дарга (Т.Цэвэлмаа), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060648